

**“Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь”-төслийн хүрээнд
Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгино-Хайрхан дүүрэг болон Сэлэнгэ, Баянхонгор
аймгуудын төрийн өмчийн цэцэрлэгүүд, өрхийн эмнэлгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд
зориулсан дэд бүтцийн засвар хийх ажлын удирдамж**

1. Ажлын үндэслэл, хэрэгцээ

Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Хөтөлбөр нь 2024 оноос эхлэн Японы Гадаад Харилцааны Яамны Төрийн бус байгууллагыг дэмжих хөтөлбөрийн санхүүжилтээр Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг болон Баянхонгор, Сэлэнгэ аймагын төрийн өмчийн 5 цэцэрлэг, 5 өрхийн эмнэлгүүдэд “Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь”-ын төслийг дээр хэрэгжүүлнэ.

Энэхүү төсөлд тусгай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан өрхийн эмнэлэг, цэцэрлэгийн орчин, дэд бүтцийг сайжруулах зорилгоор ариун цэврийн өрөө, тэргэнцэртэй хүүхдэд зориулсан налуу зам, шатны зориулалтын бариул хийж тоноглох зэрэг шаардлагатай байгаа юм. Уг засварын ажилд 5 цэцэрлэг, 5 өрхийн эмнэлэгт хийгдэх дараах ажлууд багтсан болно.

	Сургуулиуд	Хийгдэх ажил
1.	БЗД-ийн 32 дугаар цэцэрлэг	1) Цэцэрлэгийн байрны давхар хоорондын шатанд дэмжих бариул угсрах 2) Орох хаалганы дотор талыг налуу болгох 3) 2 ангийн ариун цэврийн өрөөнд ТХХ-д зориулсан суултуур, угаалтуур, туслах тоноглолын хамт шинээр хийлгэх 4) Цэцэрлэгийн төв орох хаалганы шатанд налуу зам, туслах бариулын хамт хийлгэх
2.	БЗД-ийн “Ачлахуй” өрхийн эмнэлэг	1) Ариун цэврийг өрөөг засварлаж, туслах тоноглол хийлгэх
3.	Баянхонгор аймгийн 16- дугаар цэцэрлэг	1) Цэцэрлэгийн байрны давхар хоорондын 3 шатанд дэмжих бариул угсрах 2) 6 ангийн ариун цэврийн өрөөнд ТХХ-д зориулсан суултуур, угаалтуур, туслах тоноглолын хамт шинээр хийлгэх
4.	Баянхонгор аймгийн “Энх бүрд” өрхийн эмнэлэг	1) Ариун цэврийн өрөөг хүүхдэд ээлтэй байдлаар засварлаж, туслах тоноглолыг хийлгэх 2) Гадна талын шатанд налуу зам хийлгэх
5.	СХД-ийн 117 дугаар цэцэрлэг	1) Хүүхэд хөгжлийн танхим байгуулан тохижуулах бүлгийн танхим болон орох гол хаалганы хоорондох коридорын хананд туслах бариул хийх 2) Цэцэрлэгийн 4 ангийн ариун цэврийн өрөөнд зориулалтын суултуур, угаалтуур, туслах тоноглолын хамт шинээр хийлгэх 3) Цэцэрлэгийн төв орох хаалганы довжоонд налуу зам, туслах бариулын хамт хийлгэх
6.	СХД-ийн “Ээлтэй” өрхийн эмнэлэг	1) Өрхийн эмнэлгийн 1 ариун цэврийн өрөөг засварлаж, туслах хэрэгслээр тоноглох 2) Гадна талын шатанд налуу зам хийлгэх
7.	ЧД-ийн “Энэрэнгүй үйлст” өрхийн эмнэлэг	1) Өрхийн эмнэлгийн ариун цэврийн өрөөг зориулалтын дагуу засварлах 2) Дотор талын шатанд туслах бариул хийлгэх

8.	ЧД-ийн 18 дугаар цэцэрлэг	1) Цэцэрлэгийн 4 ангийн ариун цэврийн өрөөнд зориулалтын суултуур, угаалтуур, туслах тоноглолын хамт шинээр хийлгэх 2) Коридорын хананд туслах бариул хийлгэх
9.	Сэлэнгэ аймгийн 6 дугаар цэцэрлэг	1) Дотор талын нэг талын хананд туслах бариул хийлгэх 2) Цэцэрлэгийн 2 ангийн ариун цэврийн өрөөнд ТХХ-д зориулалтын суултуур, угаалтуур, туслах тоноглолын хамт шинээр хийлгэх 3) Гадна талын хашааны шатанд налуу зам бариулын хамт хийлгэх
10.	Сэлэнгэ аймгийн “Эмнэх” өрхийн эмнэлэг	1) Өрхийн эмнэлгийн 1 ариун цэврийн өрөөг засварлаж, туслах хэрэгслээр тоноглох 2) Гадна талын шатанд налуу зам хийлгэх 3) Дотор талын хананд туслах бариул хийлгэх

2. Засварын ажлын хугацаа

Засварын ажлын нийт хугацаа 30 хоног байна.

Гүйцэтгэх ажил	Хугацаа
Засварын ажлын нөхцөлийн талаар гүйцэтгэгч компанитай тохиролцож, гэрээнд гарын үсэг зурах	2024.05.30-2024.05.31
Төслийн зорилтот цэцэрлэг, өрхийн эмнэлгүүдэд дээр очиж засварын ажил хийж гүйцэтгэх	2024.06.02-2024.06.30
Захиалагчийн тавьсан шаардлагын дагуу нэмэгдэл ажил гүйцэтгэх, сайжруулах	2024.06.31-2024.07.5
Засварын ажлыг хүлээлгэн өгөх	2024.07.5-2024.07.10

3. Барилгын компанид тавигдах ерөнхий шаардлага

- Барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээтэй байх
- Сургууль, цэцэрлэгийн барилга барих, засварлах чиглэлээр 5 буюу түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх
- Хийгдэх барилгын ажлын засварыг хийх хүн хүч, техник хэрэгсэл, материалын нөөцтэй байх